МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр Дугаар А/180 Есөнбулаг

Нэг удаагийн дэмжлэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэ сумын “Эрдэнэ-Эрчим хүч ААТҮГ нь нээлттэй дуудлага худалдаагаар хувьчлагдсан тул тус газрын захирлаар ажиллаж байсан А.Мягмаржавд 4,838,355 (дөрвөн сая найман зуун гучин найман мянга гурван зуун тавин таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л. Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:My documet ZAX A-4
8200010471